

MSE: 

# Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал

---

Хүчтэй. Хамтдаа.

**ХУРЛЫН ИРЦ**

**ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

## “АРД ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №1

2025 оны 9 сарын 10-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон  
хурлын хүчин төгөлдөр тооцох тухай

**Компанийн нэр:** Ард Даатгал ХК

**Компанийн хаяг:** Компанийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305 тоот

**Хурлын төрөл:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал

**Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсан огноо, газар:** Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2025 оны 9 сарын 10-ны өдрийн 14:00 цагт Цахимаар (АрдАпп)

**Бүртгэлийн өдөр:** 2025 оны 8 сарын 18-ны өдөр

**Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас ирүүлсэн сүүлийн хугацаа:** 2025 оны 9 сарын 8-ны өдрийн 15:00 цаг хүртэл

**Тооллогын комисс:** Ө.Бямбагэрэл, Ч. Даваацэрэн, А.Эрхбилгүүн

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дугаар хэсэг болон 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр хэсгийг тус тус үндэслэн

### ТОГТООХ НЬ:


1. Саналын эрхтэй 25,000,000 ширхэг энгийн хувьцаанаас ... ширхэг буюу ... хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байна.
2. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дүгээр хэсгийг үндэслэн тус хурал хүчин төгөлдөр болно.

# ХУРЛЫН ДЭГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- |             |                                                                                                                                                                                                                   |
|-------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 14:00-14:05 | ➤ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээх                                                                                                                                                                         |
| 14:05-14:10 | ➤ Хурлын ирц танилцуулах (Тооллогын комисс)                                                                                                                                                                       |
| 14:10-14:15 | ➤ Хурлын хөтөлбөр, хэлэлцэх асуудал танилцуулах                                                                                                                                                                   |
| 14:15-14:30 | ➤ Хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу танилцуулга хийх <ol style="list-style-type: none"><li>1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлэх тухай;</li><li>2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай;</li></ol> |
| 14:30-14:35 | ➤ Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт                                                                                                                                                               |
| 14:35-14:40 | ➤ Санал хураалт                                                                                                                                                                                                   |
| 14:40-14:45 | ➤ Санал хураалтын дүнг нэгтгэн, Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах                                                                                                                                 |
| 14:45-14:50 | ➤ Хурлаас гарсан шийдвэрийг Хурлын дарга танилцуулж, Хурлыг хаах                                                                                                                                                  |

# ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ - 1

## КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ



# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**ТУЗ-ийн дарга**  
О.Одбаяр



**ТУЗ-ийн гишүүн**  
Б.Золбоо



**ТУЗ-ийн хараат бус гишүүн**  
Н.Хосбаяр



**ТУЗ-ийн гишүүн**  
Г.Уянга



**ТУЗ-ийн гишүүн**  
Г.Цогбадрах



**ТУЗ-ийн хараат бус гишүүн**  
Б.Болорчимэг



**ТУЗ-ийн гишүүн**  
Н.Эрдэнэтулга



**ТУЗ-ийн гишүүн**  
С.Оргил



**ТУЗ-ийн хараат бус гишүүн**  
Г.Хонгорзул

5

Ээлжит  
Ээлжит бус

1

Эчнээ

6

Хуралдсан тоо

15

Шийдвэрлэсэн  
асуудлын тоо

## ТУЗ-өөр шийдвэрлэсэн онцлох шийдвэрүүд:

- ✓ Ногдол ашиг хуваарилах эсэх тухай
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай
- ✓ 2024 оны аудитлагдсан тайланг дүгнэж ТУЗ-ийн дүгнэлт гарган батлах тухай
- ✓ Гүйцэтгэх захирлын үнэлгээ батлах тухай
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах тухай



ДААТГАЛ  
SINCE 1994


## АРД ДААТГАЛ ХК-ИЙН Чанар ба мэдээллийн аюулгүй байдлын бодлого




### Бид

- Монгол улсын хууль тогтоомжийн шаардлагуудад байнга нийцэж ажиллана.
- Даатгалын зах зээлд харилцагчдынхаа хэрэгцээ, хүлээлт, шаардлагад нийцсэн шинэлэг бүтээгдэхүүн болон дэвшилтэт технологид (автоматжуулалт, хиймэл оюун) суурилсан даатгалын үйлчилгээг шуурхай, найдвартай, мэргэжлийн түвшинд хүргэн ажиллана.
- Аливаа санхүүгийн луйвар, залилан, хууль бус үйлдлээс ангид байж байгууллагын бүх түвшинд ажилтнуудынхаа ёс зүйт хандлагыг эрхэмлэн сахиулна.
- Өөрийн болон харилцагчдын бүх төрлийн мэдээлэл, мэдээллийн хүртээмжтэй, бүрэн бүтэн байдал, мэдээллийн системийн нууцлалыг тасралтгүй ханган, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн менежментийг тогтмол хэрэгжүүлж ажиллана.
- Нээлттэй хувьцаат компанийн хувьд хүлээсэн үүргийн дагуу холбогдох талуудад мэдээлэх шаардлагатай мэдээллийн үнэн зөв, ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангаж ажиллана.
- Өдөр тутмын үйл ажиллагаандаа зөвхөн бизнесийн ашгийг эрхэмлэх бус олон улсын хөгжлийн чиг хандлагыг даган бүтээгдэхүүн, үйлчилгээгээ тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн нийгэмд эерэг нөлөөллийг бий болгохыг зорьж ажиллана.
- Компанийн андеррайтинг болон хөрөнгийн удирдлагыг үр ашигтай түвшинд байлгаж, эрсдэлийн удирдлагыг системтэйгээр сайжруулж, нэгдмэл менежментийн тогтолцоонд нийцүүлэн ажиллана.
- Салбарын болон олон улсын тэргүүн туршлага, стандартад байнга суралцаж чанар болон мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооныхоо үр нөлөөтэй хэрэгжилтийг тасралтгүй сайжруулна.


Нийт хөрөнгө  
сая төгрөг




Эздийн өмч  
сая төгрөг




Нийт нөөц сан  
сая төгрөг




Нийт хураамжийн орлого  
сая төгрөг



Нийт нөхөн төлбөр  
сая төгрөг



Цэвэр ашиг  
сая төгрөг



# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

| №                        | Хувьцаа эзэмшигчид             | 12/31/2024 |         | 08/18/2025 |         | Өөрчлөлт    |
|--------------------------|--------------------------------|------------|---------|------------|---------|-------------|
|                          |                                | Тоо        | %       | Тоо        | %       |             |
| 1                        | Ард Санхүүгийн Нэгдэл ХК*      | 14,216,586 | 56.87%  | 15,774,979 | 63.10%  | 1,558,393   |
| 2                        | С. Оргил                       | 1,164,822  | 4.66%   | 1,164,822  | 4.66%   | -           |
| 3                        | Н. Мөнхнасан                   | 1,125,742  | 4.50%   | -          | 0.00%   | (1,125,742) |
| 4                        | Г. Бат-Эрдэнэ                  | 1,111,141  | 4.44%   | 1,042,221  | 4.17%   | (68,920)    |
| 5                        | Бодь Даатгал                   | 857,135    | 3.43%   | 857,135    | 3.43%   | -           |
| 6                        | Энержи Интернэйшнл Капитал ХХК | 820,750    | 3.28%   | 820,750    | 3.28%   | -           |
| 7                        | БиДиСек ҮЦК                    | 450,094    | 1.80%   | 279,462    | 1.12%   | (170,632)   |
| 8                        | А. Сүхдорж                     | 203,994    | 0.82%   | 203,994    | 0.82%   | -           |
| 9                        | Ч. Амарбаатар                  | 166,000    | 0.66%   | 166,000    | 0.66%   | -           |
| 10                       | Бусад                          | 4,883,736  | 19.53%  | 4,690,637  | 18.76%  | (193,099)   |
| НИЙТ                     |                                | 25,000,000 | 100.00% | 25,000,000 | 100.00% | -           |
| Хувьцаа эзэмшигчдийн тоо |                                | 9,506      |         | 9,342      |         | -164        |

\*Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний хамаарал бүхий компаниуд

## Одоогийн байгаа бүтэц

| №        | Нэр                            | Тоо ширхэг | Эзлэх хувь | Нэгж үнэ | Нийт дүн      |
|----------|--------------------------------|------------|------------|----------|---------------|
| 1        | Ард Санхүүгийн Нэгдэл ХК*      | 15,774,979 | 62.73%     | 200      | 3,154,995,800 |
| 2        | С. Оргил                       | 1,164,822  | 4.66%      | 200      | 232,964,400   |
| 3        | Г. Бат-Эрдэнэ                  | 1,042,221  | 4.37%      | 200      | 208,444,200   |
| 4        | Бодь Даатгал                   | 857,135    | 3.43%      | 200      | 171,427,000   |
| 5        | Энержи Интернэйшнл Капитал ХХК | 820,750    | 3.28%      | 200      | 164,150,000   |
| 6        | БиДиСек ҮЦК                    | 279,462    | 1.16%      | 200      | 55,892,400    |
| 7        | Бусад                          | 5,060,631  | 20.37%     | 200      | 1,012,126,200 |
| НИЙТ ДҮН |                                | 25,000,000 | 100%       |          | 5,000,000,000 |

## Нэмэгдүүлсний дараах бүтэц

| №        | Нэр                            | Тоо ширхэг | Эзлэх хувь | Нэгж үнэ | Нийт дүн       |
|----------|--------------------------------|------------|------------|----------|----------------|
| 1        | Ард Санхүүгийн Нэгдэл ХК*      | 15,774,979 | 62.73%     | 600      | 9,464,987,400  |
| 2        | С. Оргил                       | 1,164,822  | 4.66%      | 600      | 698,893,200    |
| 3        | Г. Бат-Эрдэнэ                  | 1,042,221  | 4.37%      | 600      | 625,332,600    |
| 4        | Бодь Даатгал                   | 857,135    | 3.43%      | 600      | 514,281,000    |
| 5        | Энержи Интернэйшнл Капитал ХХК | 820,750    | 3.28%      | 600      | 492,450,000    |
| 6        | БиДиСек ҮЦК                    | 279,462    | 1.16%      | 600      | 167,677,200    |
| 7        | Бусад                          | 5,060,631  | 20.37%     | 600      | 3,036,378,600  |
| НИЙТ ДҮН |                                | 25,000,000 | 100%       |          | 15,000,000,000 |

# ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ - 2

## ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1. Ард Даатгал ХК-ийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсугай.

1.1. Ард Даатгал ХК-ийн дүрмийн 1.5-д “Компанийн албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305 тоот” гэж заасныг “Компанийн албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 17 давхар, 1710 тоот” гэж өөрчлөх;

1.2. Компанийн дүрмийн 4.1-д “Компани нь 200 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 25,000,000 ширхэг энгийн хувьцаатай байна” гэж заасныг “Компани нь 600 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 25,000,000 ширхэг энгийн хувьцаатай байна” гэж өөрчлөх;

# АСУУЛТ ХАРИУЛТ

# САНАЛ ХУРААЛТ

# САНАЛ ХУРААЛТЫН ДҮН ТООЛЛОГЫН КОМИСС

# ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

## “АРД ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №2

2025 оны 9 сарын 10-ны өдөр

Санал хураалтын дүнгийн талаар

**Компанийн нэр:** Ард Даатгал ХК

**Компанийн хаяг:** Компанийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305 тоот

**Хурлын төрөл:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

**Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсан огноо, газар:** Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2025 оны 9 сарын 10-ны өдрийн 14:00 цагт Цахимаар (АрдАпп)

**Бүртгэлийн өдөр:** 2025 оны 8 сарын 18-ны өдөр

**Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас ирүүлсэн сүүлийн хугацаа:** 2025 оны 9 сарын 8-ны өдрийн 15:00 цаг хүртэл

**Тооллогын комисс:** Ө.Бямбагэрэл, Ч. Даваацэрэн, А.Эрхбилгүүн

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь заалтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж, санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хурлаар хэлэлцсэн Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт ... ширхэг ... хувийн хувьцааг эзэмшигчид саналын хуудсаар зөвшөөрсөн санал өгч, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалтад зааснаар Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх тухай асуудлыг батлан шийдвэрлэв.
2. Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс татгалзсан, түдгэлзсэн болон хүчингүй саналын хуудас байхгүй болно.

# ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

## “АРД ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ №3

2025 оны 9 сарын 10-ны өдөр

Санал хураалтын дүнгийн талаар

**Компанийн нэр:** Ард Даатгал ХК

**Компанийн хаяг:** Компанийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305 тоот

**Хурлын төрөл:** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

**Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсан огноо, газар:** Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2025 оны 9 сарын 10-ны өдрийн 14:00 цагт Цахимаар (АрдАпп)

**Бүртгэлийн өдөр:** 2025 оны 8 сарын 18-ны өдөр

**Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас ирүүлсэн сүүлийн хугацаа:** 2025 оны 9 сарын 8-ны өдрийн 15:00 цаг хүртэл

**Тооллогын комисс:** Ө.Бямбагэрэл, Ч. Даваацэрэн, А.Эрхбилгүүн

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь заалтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж, санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хурлаар хэлэлцсэн Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт ... ширхэг ... хувийн хувьцааг эзэмшигчид саналын хуудсаар зөвшөөрсөн санал өгч, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалтад зааснаар Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг батлан шийдвэрлэв.
2. Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс татгалзсан, түдгэлзсэн болон хүчингүй саналын хуудас байхгүй болно.

# ХУРЛААС ГАРСАН ШИЙДВЭР ТАНИЛЦУУЛАХ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 9 сарын 10-ны өдөр

Дугаар 04/25

Улаанбаатар хот

*Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх тухай*

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.1, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16, 2025 оны 9 сарын 10-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын №2 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Ард Даатгал ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө буюу нэгж хувьцааны үнийг 600 (зургаан зуун) төгрөг болгон нэмэгдүүлсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж өөрчлөлтийг санхүүгийн тайланд тусгах, хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Н.Эрдэнэтулга)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Н.ХОСБАЯР

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 9 сарын 10-ны өдөр

Дугаар 05/25

Улаанбаатар хот

*Компанийн дүрэм нэмэлт  
өөрчлөлт оруулах тухай*

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.5, 62 дугаар зүйлийн 62.1.1 дахь хэсэг, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6.1 дэх хэсэг болон 2025 оны 9 сарын 10-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын №3 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Ард Даатгал ХК-ийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсугай.
  - 1.1 Ард Даатгал ХК-ийн дүрмийн 1.5-д “Компанийн албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1305 тоот” гэж заасныг “Компанийн албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 17 давхар, 1710 тоот” гэж өөрчлөх;

- 1.2. Компанийн дүрмийн 4.1-д “Компани нь 200 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 25,000,000 ширхэг энгийн хувьцаатай байна” гэж заасныг “Компани нь 600 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 25,000,000 ширхэг энгийн хувьцаатай байна” гэж өөрчлөх;
2. Энэхүү шийдвэрийн 1 дахь хэсэгт заасан нэмэлт өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Н.Эрдэнэтулга)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Н.ХОСБАЯР

Хүчтэй. Хамтдаа.